



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 08 сарын 17 өдөр

Дугаар А/118

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах тухай” 78 тоот зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны “Журам шинэчлэн батлах, журамд өөрчлөлт оруулах тухай” 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам”, Монгол Улсын Засгийн Газрын 2014 оны “Журам, чиглэл шинэчлэх батлах тухай” 71 дүгээр тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны “Журам батлах тухай” А/316 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах оюутныг сонгон шалгаруулах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын “Сургалтын төрийн сангийн зээлийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай” 2014 оны А/219 дугаар тушаалын Энхбаяр овогтой Төрбат-д холбогдох хэсгийг Баяраа овогтой Үүрийнтуяа Маккуаэрийн их сургууль, Сэтгэл судлал мэргэжлээр 4 жил, Жаргалсайхан овогтой Энх-Идэрд холбогдох хэсгийг Галиндэв овогтой Гүен Калифорны их сургууль, Эдийн засагч мэргэжлээр 4 жил, Хишигсүрэн овогтой Номинд холбогдох хэсгийг Лхагваа овогтой Батмөнх Нью саут вальс их сургууль, Уул уурхайн инженер мэргэжлээр 4 жил, Батболд овогтой Булганд холбогдох хэсгийг Батнасан овогтой Буянжаргал

Торонтогийн их сургууль, Олон улсын харилцаа, эдийн засагч мэргэжлээр 3 жил, Баасанхүү овогтой Номинд холбогдох хэсгийг Энхсайхан овогтой Билгүүтэй Фордхамын их сургууль, Биологийн шинжлэх ухаан мэргэжлээр 3 жил, Бат-Мөнх овогтой Шүрд холбогдох хэсгийг Отгонболд овогтой Амин-Эрдэнэ Вашингтоны их сургууль, Мэдээллийн технологи мэргэжлээр 4 жил, Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайдын "Тушаалд өөрчлөлт оруулах тухай" 2017 оны А/21 дугаар тушаалын Лхагвасүрэн овогтой Сарнай Сидней их сургууль гэснийг Нью саут вальс их сургууль, Нислэгийн удирдлага мэргэжлээр 4 жил, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын "Сургалтын төрийн сангийн зээлийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай" 2016 оны А/215 дугаар тушаалын Амарсайхан овогтой Хүслэн Манчестерийн их сургууль гэснийг Свонсий их сургууль, Боловсрол судлал 3 жил гэж тус тус өөрчилсүгэй.

2. Суралцагчтай зохих журмын дагуу гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Боловсролын зээлийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гадаад хамтын ажиллагааны хэлтэс /Э.Энх-Амгалан/-т нарт тус тус даалгасугай.

САЙД

The image shows a rectangular official stamp with a grid pattern. Overlaid on the stamp is a handwritten signature in black ink. The signature is stylized and appears to read 'Г. Чулуунбаатар'.

Г.ЧУЛУУНБААТАР